



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№128 /342/

2022.07.25

Цаг үе, үйл явдал

ХУРАНДАА АЛЕКСАНДР КАВАЛКАНТИ СИМОНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, ЗХЖШ-ын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд, Энхийг дэмжих хэлтсийн дарга дэд хурандаа Б.Энхцаг нар НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын Нэгдсэн сургалтын албаны Цэргийн сургалт хариуцсан офицер хурандаа Александр Кавалканти Симоныг хүлээн авч уулзав.

Уулзалтын эхэнд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга Монгол Улсын Зэвсэгт хүчинд өнгөрсөн саруудад зохион байгуулсан томоохон арга

хэмжээнүүдийн талаар ерөнхий мэдээлэл өглөө. Тухайлбал, Энэтхэг-Номхон далай дахь АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан "Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны сургуулийг гадаадын 15 орны 600 орчим цэргийн алба хаагчдыг оролцуулан амжилттай зохион байгуулсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор НҮБ-ын "Эмэгтэйчүүд-Энх тайван, аюулгүй байдал" сэдэвт бүс нутгийн орнуудын олон улсын бага хурлыг Улаанбаатар хотод 30 гаруй орны 60 орчим оролцогчидтойгоор зохион байгуулав. Энэхүү хурлын

үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийн ажиллагаа хариуцсан орлогч ноён Жейн Перри Лакрау албан ёсны айлчлал хийсэн зэрэг мэдээллүүдийг хүргэв. Үргэлжлүүлэн Монгол Улсыг Зэвсэгт хүчин АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран олон төрлийн сургалтуудыг тасралтгүй, тогтмол явуулж, бие бүрэлдэхүүнийхээ мэргэжлийн бэлтгэлжилтийг сайжруулахын зэрэгцээ НҮБ-ын Энхийн ажиллагаанд оролцоогоо нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байгаа бөгөөд өнгөрөгч 5 дугаар сард "Мотобуудлагын батальон", "Цэргийн хээрийн II шатны эмнэлэг"-ийн цэргийн

багуудын бэлтгэлийг НҮБ-ын Үнэлгээ зөвлөмжийн багийн үзлэгт амжилттай шалгагдсан талаараа харилцан мэдээлэл солилцлоо.

Үүний хариуд хурандаа Александр Кавалканти Симон Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй үйл хэрэгт баярлаж явдгаа илэрхийлэхийн зэрэгцээ Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдаж буй "НҮБ-ын цэргийн ажиглагчийн дамжаа"-ны явцтай танилцах талаараа мэдээлэл өглөө.



АРТИЛЛЕРИЙН ЦЭРГЭЭС ГУРАВ ДАХЬ ГАВЬЯАТ ТӨРЛӨӨ



Монгол Улсын ЕрөнхМонгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн зарлигаар Монгол Улсын Үйлчилгээний гавьяат ажилтан цолыг бэлтгэл дэд хурандаа Ж.Дамдинсүрэнд хүртээлээ.

Одоо бэлтгэл дэд хурандаа Ж.Дамдинсүрэн нь "Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбоо"-г удирдан автобусны үйлчилгээг сайжруулах, нийтэд хүртээмжтэй болгох, үнийг тогтвортой барих чиглэлээр ихээхэн шинэлэг, бүтээлч ажлуудыг санаачлан гардан хэрэгжүүлж байгаа юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌧️ 10


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.173.00	3.180.0
EUR 🇪🇺	3.250.0	3.270.0
CNY 🇨🇳	471.00	474.00
RUB 🇷🇺	51.50	52.80
JPY 🇯🇵	22.90	23.18
KRW 🇰🇷	2.38	2.41

ЗУРХАЙ



2022.07.25 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 27

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.20-20.38

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, сэтгэлд сөвтэй газар очих, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 572,864,660

Эдгэрсэн

Нийт: 542,875,721

Нас барсан

Нийт: 6,398,602

Цахим шууданд

“ЦЭРГИЙН РАЛЛИ” ТЭМЦЭЭНД ХОЁР ДАХЬ УДААГАА ОРОЛЦОНО



Олон улсын “Цэргийн наадам”-ын хүрээнд зохион байгуулагддаг “Цэргийн ралли-2022” олон улсын цэргийн мэргэжлийн тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид хоёр дахь удаагаа оролцохоор Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн байрлалд бэлтгэлээ хангаж байна.

2021 онд зохион байгуулагдсан тус тэмцээнд найман улс оролцож байсан бөгөөд тус тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид анх удаагаа оролцож 3 алт, 2 хүрэл медаль хүртэж бахархам амжилт гаргасан. Энэ жил уг тэмцээний нэгдүгээр шат “Нэг бүрийн уралдаан” Увс аймгийн

Улаангомхотын нутагт 8 дугаар сарын 15-нд, хоёрдугаар шат “Нэхэн хөөх уралдаан”, гуравдугаар шат “Багийн уралдаан”, дөрөвдүгээр шат “Буудлага”-ын тэмцээнүүд Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улсын нийслэл Кызыл хотод 8 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд хоёр улс дамжин

зохион байгуулагдана. Одоогийн байдлаар Монгол, ОХУ, Беларусь, Узбекистан зэрэг улс орны баг тамирчид оролцоно гэдгээ албан ёсоор мэдэгдээд байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний баг Зэвсэгт хүчний 011, 089, 186 дугаар ангиудын офицер, ахлагчдаас бүрдэж байгаа юм.

Ахлах дэслэгч
Д.БЯМБАБАЯР

“АРАВТ” УРАЛДААН ГУРАВ ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА

“Олон улсын цэргийн наадам”-ын хүрээнд “Аравт” олон улсын морин цэргийн уралдаан Монгол Улсад ирэх 8 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна.

Энэхүү уралдаан нь бэлтгэлийн, алсын зайны морин маршийн, богино зайны холимог буухиа, төгсгөлийн буюу тэмцээнийг дүгнэх гэсэн дөрвөн үе шаттай явагдана.

Нэгдүгээр шат буюу тэмцээндээ бэлтгэх үе шатанд оролцогч орны баг тамирчдыг хүлээн авч байрлуулах, аюулгүй ажиллагааны заавар танилцуулах, энэ чиглэлээр сургалтуудыг явуулах, оролцогчдыг уралдааны бэлтгэлийг хангуулах, морьтой сургалт, дадлага хийлгэх, уралдааны маршрутыг баг тамирчдад танилцуулах зэрэг арга хэмжээнүүд багтаж байгаа юм.

Хоёрдугаар шат буюу алсын зайны морин маршийн шатанд уралдаанд оролцогч орны цэргийн алба хаагчид уул, ой мод, гол ус, элс, бартаа саад бүхий 130 км замыг маршрутын дагуу туулна. Гэхдээ зүгээр туулаад өнгөрөхгүй, даалгавар гүйцэтгэх явдалаа усан болон мина зүүлтэй талбай туулах, морь бэлтгэх, уналтад бэлтгэх, бартаа саад бүхий газарт хоноглох, эцэст нь шархтанд эмнэлгийн анхан

шатны тусламж үзүүлэх, шархтан болон сум галт хэрэглэлийг хөнөөлийн голомтоос татан гаргах зэрэг даалгавруудыг гүйцэтгэх юм. Усан саадаар урсгал ширүүн гол туулж, минын саадыг туулах бол морьт сэлгэх даалгавраар адуун сүргээс морьт бугуйлдаж уналтад бэлдэх юм.

Харин гуравдугаар шат буюу ойрын зайны холимог буухиагаар оролцогч орны баг тамирчид явганаар болон морьтойгоор тогтоосон маршрутын дагуу байрлах цэгүүдэд гранат шидэх, саадын зурвас туулах, буудлагын дасгал гүйцэтгэх, тактикийн ажиллагаа, морины давхилт дунд гранат шидэх зэрэг даалгавруудыг гүйцэтгэн барианд орох юм.

Төгсгөлд нь тэмцээний дүнг нэгтгэж, уралдаанд амжилт үзүүлсэн баг тамирчдад шагналыг гардуулах ёслол болно.

Ташрамд онцлоход, уралдааны бэлтгэл явцад Монгол Улсын зан заншил, түүх, соёл уламжлалыг сурталчлах, цэргийн алба хаагчдын нөхөрлөлийг бататгах хүрээнд бэсрэг наадам, соёл урлаг болон спортын төдөрлөгүүд, “Адуучийн тэмцээ” зэрэг олон арга хэмжээний дагуу уралдаанд зохион байгуулагдах “Аравт”-ын харын албанд анхан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН ЗАЛУУЧУУДЫН АЗИ ТИВИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД “АЛДАР”-ЫН ТАМИРЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



“Алдар” спорт хороо

Өнгөрсөн сард Узбекистан Улсын Ташкент хотод зохион байгуулагдсан хүндийн өргөлтийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Батлан хамгаалах яамны харьяа “Алдар” спорт хорооны дасгалжуулагч дэслэгч Ч.Март, тамирчин ОУХМ Б.Хонгорзул, ОУХМ Б.Эрдэнэзул нар амжилттай оролцоод ирлээ. Тодруулбал, 59 кг-ийн жинд ОУХМ Б.Хонгорзул огцом өргөлтөөр 84 кг өргөж хүрэл медаль, түлхэлттэй өргөлтөөр 108 кг түлхсэнээр мөнгөн медаль, өргөлтийн нийлбэр дүнгээр хүрэл медаль хүртсэн бол 49 кг-ийн жинд ОУХМ Б.Эрдэнэзул огцом өргөлтөөр 69 кг өргөж 7 дугаар байр, түлхэлттэй өргөлтөөр 88 кг түлхэж 5 дугаар байр, өргөлтийн нийлбэр дүнгээр 6 дугаар байрт тус тус шалгарсан юм.

ӨСВӨР ҮЕ ЗАЛУУЧУУДЫН БАГ 5 АЛТ, 1 МӨНГӨ, 1 ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Байт харвааны өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 21-24-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байрлах байт харвааны “360” төв дээр зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 11 байгууллагын 124 тамирчин өрсөлдсөнөөс Батлан хамгаалах яамны

харьяа “Алдар” спорт хорооны ахмад Б.Ганзориг дасгалжуулагчтай өсвөр үе, залуучуудын баг 5 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж, байгууллагын дүнгээр дэд байр эзэллээ. Үүнд:

- Залуучууд охидын төрөлд О.Халиунсайхан алтан медаль.
- 3 а л у у ч у д ы н

холимог багийн төрөлд СМ Э.Батбилэг, О.Халиунсайхан нар мөнгөн медаль.

- Ө с в ө р и й н хөвгүүдийн төрөлд спортын дэд мастер Б.Буянтушиг алт, Ө.Баярчулуун хүрэл медаль.
- Өсвөрийн холимог багийн төрөлд спортын дэд мастер Б.Буянтушиг,

Г.Ариунтунгалаг нар алтан медаль.

- Ө с в ө р и й н хөвгүүдийн багийн төрөлд спортын дэд мастер Б.Буянтушиг Ө.Баярчулуун, С.Орчлон нар алтан медаль.
- Өсвөрийн охидын багийн төрөлд З.Хулан, Г.Ариунтунгалаг, А.Мишээл нар алтан медаль тус тус хүртлээ.